# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
# ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүгээр сарын 29-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот

**“Батс кредит ББСБ” ХХК-ийн итгэлцэлийн болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”БАТС кредит ББСБ” ХХК-ийн итгэлцэлийн болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2.Үйл ажиллагааны төрөлд орсон өөрчлөлтийг Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, холбогдох баримтыг 2009 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “БАТС кредит ББСБ” ХХК /Д.Инжиндунгарааш/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА О.ГАНБАТ